

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дэлгэрийн Ням	Дугаар	L245
Оршин суугаа аймаг	Өмнөговь	Оршин суугаа сум	Дундговь аймгийн Дэлгэрхангай сум
Төрсөн газар	Аймгийн Мандал-Овоо сум	Төрсөн он	1934
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хошуу хийд, Турын хийд	Сүм хийдийн дугаар	ӨГМО 001
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 5-р сарын 27	Ярилцлага авсан хүн	Ц.Гантулга



Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Хошуу хийд, Турын хийд

Гантулга: За монголын шашин сүм хийдийн түүхэн товчоо төслийн судалгааны Е багийнхан Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт ажиллаж байна. Бид нар Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын малчин Дэлгэрийн Ням гуайнд ирээд байна. Дэлгэрийн Ням гуай бол уг нь уул харъяаллаараа бол Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын Онгийн голын хошуу хурлын өврөөр нутаглаж байсан хүн юм байна. За энэ хүнээс бид Хошуу хийд болон тэр Турын хийдийн, Турын голын өмнө байрлах Турын хийдийн талаар ам мэдээ авах гэж байна.Тэгээд одоо ярилцлагаа эхлэе. За энэ Өвгөн хийдийн талаар, сүм хийдийнх нь тухай товч мэдээлэл өгнө үү? За ер нь ийм ийм юм сонсож байсан гээд?

Ням: За би, намайг бага хорин хэдтэй байхад л юм байна даа.Балдандорж гэдэг өвгөний хуучилж байсан хуучийг ярья аа.Тэр хүн энэ Хошуу хийдтэй чацуу гэж ярьж байсан.Жаран настай байхдаа энэ Хошуу хийдийг ингээд сүйдээд, лам нар нь баригдаад ийм боллоо гэж тэр өвгөн ярьж байсан.Тэгэхэд тэрний түрүүнд ууган хүрээг бол яахав гэхлээр дахиад мөн урагшаа жаран жил болоод хуухуйд идэгдээд, шатаагдаад тэгээд урагшаа нүүсэн юм аа гэж ярьж байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Энэ Өвгөн хийд Хошуу хийд хоёр чинь ямар холбоотой вэ?

Ням: Тэр хоёр хийд бол нэг хийд л цаана тэр хуухуйд идэгдээд наанаа нүүж гарсан учиртай. Нэг л хийд.

Гантулга: Хуухуй гэдэг нь ямар улсууд байсан юм бэ, тэр талаар?

Ням: Хуухуйг болвол одоо тэрүүнийг өвгөн улсууд ярьж байгаа нь болвол одоогийн Вьетнам тэр үед л дайн хийдэг юм уу, хүлгай дээрэм хийдэг юм уу тэгж явсан юм билээ.

Гантулга: Энэ одоо Өвгөн хийд, Хошуу хийдийн нэр усны талаар энэ Өвгөн хийд , Хошуу хийд гэхээсээ өөрөөр юу гэж нэрлэдэг байсан юм бэ? Та дуулсан юм байна уу?

Ням: Тэрнийг бол би мэдэхгүй байна.Тэрнийг бол Хошуу хурал л гэдэг байсан юм.

Гантулга: Цаадахыг нь бол Өвгөн хийд л гэдэг байсан уу?

Ням: Тэр бол наад Хошуу хийд гэдэг нэр бол цаанаа байж байгаад тэгээд одоо Өвгөн хүрээ гэдэг нэр авсан байх аа.

Гантулга: Аа мөн мөн. Өвгөн хүрээ гэдэг нь бол хуучин туурь нь биз дээ, тийм ээ?

Ням: Тийм.

Гантулга: Аа зөв зөв. Тэгээд наанаа ирээд л Хошуу хурал нэртэй болсон?

Ням: Тийм.

Гантулга: Хэдий үед байсан гэдгийг нь бол түрүүн хэллээ ш дээ. Тэр гучин хэдэн оноос өмнө байсан гээд бодохоор л тооцоод үзэхэд жар жараараа гээд бодохоор бол өвгөн хийд нь болвол?

Ням: Зуун хорин жилийн өмнө л , 1937 оноос өмнө зуун хорин жилд л байгуулагдсан.

Гантулга: Одоо морь , хонь гэдэг шиг жилээрээ яривал, тэр жилд , тийм жаранд гэсэн дуулсан юм бол байхгүй юу?

Ням: За одоо хэлж мэдэх юм алга аа.

Гантулга: Энэ одоо Өвгөн хийд, Турын хийд , одоо Хошуу хийд эд нараас чинь ойролцоо ямар сүм хийд байдаг байсан бэ?

Ням: За одоо урагшаа тэр Мандал-Овоогийн зүүнд Шар Хулсны хийд гэж байдаг байсан. Ханын цагаан суварга гэж байсан.Одоо тэгээд энэ баруунтаа Хоёр Ламын хийд байна.Ондoo хийд энэ хавьд байгаагүй байх аа.

Гантулга: Энэ Хошуу хурлыг анх одоо хэн байгуулж, цаад өвгөн хийд дээр нь байхад ч гэсэн, наана нь сүүлд сэргээхэд ч гэсэн тэр одоо анх үүсгэл санаачилсан хүн гэж байх уу?

Ням: Мэдэхгүй ээ.

Гантулга: Тийм хүний талаар?

Ням: Мэдэхгүй байна.

Гантулга: Энэ одоо Хулдын хийд, тэгээд Цагаан суваргын хийд гээд л тэгээд энэ Ламын хийд гээд л байна. Эд нар чинь одоо хоорондоо Хошуу хуралтайгаа одоо харилцаха холбоо байдаг юмуу, лам нар нь солилцож ном унших ч юм уу тийм харилцаа холбоо байсан талаар дуулсан юм байна уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ням: Байсан юм гэнэ лээ. Одоо энэ зүүн Хулстын нутагт Олдохын хийд гэж бий. За тэр урагшаа ямар хийд ч гэж байсан юм мэдэхгүй, Цэцийд нэг хийд байсан юм гэнэ лээ. Ширээт ламын хийд гэл үү , үгүй билүү.

Гантулга: Хаана байсан гэнэ ээ?

Ням: Цэцийд.

Гантулга: Цэций гэдэг нь ?

Ням: Цогтцэций.

Гантулга: Аан зөв. Хулд гэдэг нь бас Дундговийн Хулд сум уу?

Ням: Тийм.Тэгэхээр энэ хийдүүд чинь энэ бүх хийдүүдийн төв нь байхгүй юу.

Гантулга: Аан ойролцоо энэ хэдийн л ерөөсөө?

Ням: Тийм. Тэгэхээр эд нар чинь яах вэ гэхлээр хоорондоо салбар салбараар нь , одоо тэндэх хийд тийм мэгзэм, тэндэх хийд нь тийм мэгзэм гэсэн байдалтай байсан байх аа.

Гантулга: Аан за за. Тэр талаар тийм юм байна. Энэ бүр Баруун зуу ч гэдэг юм уу, Гүмбэн, Утай эд нараас том том лам нар ч ирдэг гэдэг юм уу, бас тийшээ явдаг ч гэдэг юм уу, тийм холбоо харилцаа , шашны харилцаанаас дуулсан юм байна уу?

Ням: Одоол алга. Ер нь зүгээр төвдөд очоод ном сураад ирсэн гэдэг тийм талууд хүн ярьдаг л байсан.

Гантулга: Тийм үлсүүд бол байсан?

Ням: Тийм , одоо чухам хэн байсныг нь бол мэдэхгүй.

Гантулга: Одоо энэ сүм хийдүүд чинь шарын шашны , улааны гээд нэг тийм үрсгал байна аа даа?

Ням: За.

Гантулга: Одоо энэ Хошуу хурал, Өвгөн хийд хоёр чинь шарын хийд байсан юм уу, ямар хийд байсан юм? Тэр талаар мэдэх юм байна уу?

Ням: Аа шарынх.

Гантулга: Аа мөн. Цаад Өвгөн хийдийн талаар дуулсан юм бол?

Ням: Мөн тийм хийд байж байгаад л наашаа ирсэн.Тэгээд л нүүгээд ирж байгаад тэнд буусан.

Гантулга: Тэр одоо шарынх , улааных гэдэг юм уу хоорондоо холилдсон тийм юм бол байгаагүй юу?

Ням: Байхгүй.

Гантулга: Одоо энэ Хошуу хурал дээр ч байдаг юм уу, Өвгөн хийд дээр ч байдаг юмс уу аль алин дээр нь, одоо тэдэн суваргатай байсан, тийм дугантай байсан одоо ийм тийм гэх дуулсан юм, одоо үзсэн, таныг бага байхад нурж тараагүй байхад нь үзсэн юмнаасаа яриач?

Ням: Аан?

Гантулга: Одоо Хошуу хурал дээр одоо тэчнээн дуган байсан, тийм дацан байсан, тэдэн суварга ч байсан гэдэг юм уу санаж байгаа юмнаасаа та яриач? Хошуу хурал дээр багадаа үзэж харж байсан?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ням: За мэдэхгүй , Хошуу хийд дээр бол ингэж л яригдаж байсан.Чухам яадаг байсныг нь мэдэхгүй.Хөдөө явчихсан ч байдаг юм уу, төв дээрээ байгаа нь ч байдаг юм уу.Хоёр мянган лам шавилан суудаг хийд байсан юм гэнэ лээ гэж дуулсан.

Гантулга: Тэгээд одоо энэ суварга муварга хичнээн суварга байсан, Майдрын дуган байсан гээд та түрүүн ярьж байсан ш дээ?

Ням: Тийм.

Гантулга: Тэрэнтэй адилхан Майдринг суварга ч гэдэг юм уу, ийм гэрэлтэй суварга ч гэдэг юм уу таны дуулж байсан, бас яг нүдээрээ үзэж харж байсан? Тэр гучин долоон оны хэлмэгдүүлэлтээс өмнө үед бол найм естй хүүхэд байсан байна ш дээ, та болвол?

Ням: Тийм.

Гантулга: Тэгэхээр бол яг нүдээрээ үзэж аав ээжтэйгээ очиж эргэл мөргөл хийж байсан хүний хувьд бол ярихад, доторх дацан дугануудыг нь ч юмуу, тэр нь тэндээ байсан, энэ нь эндээ байсан гээд ярих юм байна уу?

Ням: За тэр голд бол голын цагаан суварга байсан.Тэрнээс зүүнхэн Майдрын дуган байсан. За тэрнээс баруухан өмнө цогчин жас байсан.Тэрнээс баруухан хойно цамын жас гэж байсан.За тэгээд одоо илүү ч мэдэхгүй нь дээ.Тэр Майдрын дуганы зүүнтээ нэг модон дуган байсан санагдаж байна.Тэрнээс л цам гардаг байсан.Хийдийнхээ зүүн хойд захад бол Хошуу ноёны хашаа байдаг байсан. Зүүн үрд захдаа бүрээ, ширээ нь байдаг байсан.За одоо илүү бол мэдээд байх юм энэ хийдийн талаар бол алга юм.

Гантулга: Одоо энэ сүм хийдүүдийг бол зөн гээд байна ш дээ, шатаасан тоосго гээд?

Ням: Тийм.

Гантулга: Тийм юмаар барьсан байсан уу, сая одоо ингээд туурин дээр нь очоод үзэхэд бол түүхий шавраар ингээд хэвлээд хийчихсэн тоосгоны мөр харагдаж байна лээ? Одоо хийсэн материал нь , модон дуган ч байдаг юм уу, тийм хөх тоосгон дуган ч байдаг юм уу, тийм дээвэртэй , тийм олон ганжиртай гээд тэр хийсэн материал нь, чимэглэл нь сэтгэлд хоногшиж үлдсэн юм байна уу?

Ням: Ер нь бол гадна талаараа бол , хөх түүхий тоосго.Тэгээд тэрний дотор талаар нь түүхий шавар тоосгоор хийж өгсөн.Тийм байсан юм. Тэгээд тэр гадна талын хөх зөн тоосгыг бол яахав ийш тийш нь барилга, хашаа хороо юманд хэрэглээд дууссан юм аа.Тэгээд одоо гол юм үлдсэн нь тэр түүхий тоосгууд, овоосон шавар л байна.

Гантулга: Одоо ингээд л өдөр тутмын хурал гээд л байдаг шүү дээ, цогчин хурал ч гэдэг юм уу?

Ням: За.

Гантулга: Тийм хурал, тэгээд одоо дүйчэн өдрүүдэд нь тийм ном хурдаг одоо арван хангал ч хурдаг гэдэг юм уу.Тэгээд ямар зан үйл хийдэг вэ, цам харайдаг байсан уу, сор залдаг байсан уу?Энэ талаар нь яривал, энэ Хошуу хурал дээр?

Ням: Цам байж л байсан.

Гантулга: Та тэрэнд орж байсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ням: Үгүй ээ, үгүй.Тэр сор залж л байсан. Тэрүүнийг багад үзээд айж л байсан.

Гантулга: Цамын цагаан өвгөнийг үзээд айж байсан гээд түрүүн бас?

Ням: Тийм.Тэр чинь л байна. Харин энүүний бол тэр Хошуу хийдийн бол гол шүтээн бурхан нь тэр Улаан сахиус байсан юм гэнэ лээ.

Гантулга: Аа мөн мөн.

Ням: Жамсран бурхан.Тэр байсан юм гэнэ лээ.

Гантулга:Тэгээд одоо Ядам , Сахиус энэ тэр гээд л хуралд байдаг тийм юмнуудыг нь нэрлэвэл? Мэддэг юм?

Ням: Мэдэх юм алга.Тэгэхээр энэ тэр Дэлгэр хангайд байхад чинь , за би бас шавь орж л байсан.Хошуу хийдийн нэг лам, одоо Цэвэгнамжил гэж гавж хүн байсан.Тэр Цэвэгнамжил гэдэг гавж хүн шоронд яваад, хэлмэгдээд тэгээд ирсэн.Тэгээд цагаатсан тийм хүн юм.Тэгээд тэр хүнд энэ Олдохын хийдийн Даансран гэж нэг өвөг лам байлаа.Тэр Хошуу хийдийн гол шүтээн нь гэж тэр улаан сахиусыг авч өгч байсан юм.Тэгээд би тэрийг гол сахиус тэр байжээ гэж мэдэж байгаа юм.

Гантулга:Одоо тэр сахиус хаана байгаа бол? Үе уламжлагдан үлдсэн болов уу?

Ням: Энэ Дэлгэр хангай дээр нэг тийм гэрэн дуган шиг юм бий.Тэрүүнд л байх ёстой доо.

Гантулга: Одоо Чойр, зурхай , эм гээд дацангууд байдаг. Тэр талаар дуулсан юм байвал? Хэдэн дацантай байсан юм?

Ням: Одоо мэдэхгүй юм.

Гантулга: Одоо цогчин сургууль гээд байдаг ш дээ, тэрийг бол мэдэхгүй юу?

Ням: Мэдэхгүй.

Гантулга: Тэр одоо орон хийдийнх нь хутагт хувилгаан том лам, тэр хүрээ хийдийнх нь эрдэмтэй лам нарын талаар тийм тийм хүн байсан юм гэнэ лээ, тийм тийм ид шид үзүүлж байсан юм гэнэ лээ энэ тэр гэсэн юм байх уу? Хамба нь?

Ням: Мэдэхгүй.

Гантулга: Төвд мөвдөөс ч юм уу, том хүрээнээс Богд лам ирэх ч гэдэг юм уу, ирж том ван тавих ч гэдэг юм уу, бурхан аравнайлах ч гэдэг юм уу, тийм тийм том үйл болж байсан уу, багад чинь? Тэгээд тэрэнд оролцож байсан дуулсан юм байна уу?

Ням: Алга.

Гантулга: Тэр лам нар нь хийдийнхээ ойролцоо тэр гороон дотроо л байсан уу?

Ням: Тэгсэн.

Гантулга: Амьдардаг газар нь гэвэл?

Ням: Тийм.Тэгээд л хөдөө явахлээрээ болохоор малтайгаа явдаг, хөдөө энэ тэр. Тийм л байсан юм байна лээ ш дээ.

Гантулга: Жасууд нь болвол Хошуу хүрээн дээрээ байсан уу, эсвэл?

Ням: Хүрээн дээрээ.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Таны мэдэхээр бол ер нь ямар ямар жас байсан, дуулснаар бол?

Ням: Үгүй одоо, цогчин жас байна, цамын жас байна.Ондoo юм алга, мэдэхгүй байна.

Гантулга: Одоо энэ том дүйчэн өдрөөр , шинийн арван таван байна, цагаан сарын хурал гээд сүсэгтэн олон олноороо цугладаг ш дээ.Тэгэхэд бол сүсэгтэн олон ямар маягаар буюн хийж, шашны зан үйл үйлддэг байсан.Одоо биеэрээ төөлж хүрээний горлыг бүтэн эргэх гэдэг юмуу, тийм юм байсан уу? Ер нь биеэрээ дан сунаж мөргөөд...?

Ням: За миний мэдэхээр л лав ингээд залбираад л , харуулдаж ойчиж байгаа юм шиг мөргөөд л байдаг байсан.Одоо хэвтэж мөргөдөг тийм юм харагдаж л байсан. Би дуурайгад л харуулдаж ойчиж л байсан.Аа зүгээр яваад, орой бүгд хурлаа ингээд олон лам нар тойрчихдог. Тэгж эргэдэг байсан, тийм зүгээр жигтэйхэн юм болж байгаа бололтой тэгж эргэдэг байсан.

Гантулга: Олон лам байсан болохоор их гоё харагддаг байсан байлгүй?

Ням: Их олон хүн байдаг байсан санагдаж байна.

Гантулга: Тэгээд том лам ирж номын абшиг , ван тавих энэ тэрт бол сүсэгтэн олон их цуглана даа. Ном айлдах энэ тэр гээд?

Ням: Тийм байлгүй дээ. Ерөөсөө хурал бол тэгж өдөр өнжинө гэж байдаггүй байсан байх аа.

Гантулга: Таныг бага байхад ер нь Хятадын наймаа , доншуурын наймаа энэ тэр гэж явдаг байсан уу, ер нь ?

Ням: Тэр Хошуу хийдийн чинь хойхно нэг баахан шавар бий.Тэр чинь одоо наймаачид байсан юм.

Гантулга: Өө тэнд бүр суурин байсан юм уу?

Ням: Суурин байсан юм.Ногоо тарьдаг байсан юм гэнэ лээ.

Гантулга: Гол устай болохоор?

Ням: Тийм. Тэгээд наймаа хийдэг.

Гантулга: Гар урлалын юм байсан болов уу?

Ням: Гар урлал ч одоо тэр барилгын улсууд ирж тэр дуган сүм юм хум барьдаг байсан байх.Энэ далиманд нь ярихад манай Хошуу хийдийн уран Балдандорж, Сайхансамба гэж хоёр хүн бол гайхалтай уран хүмүүс байсан юм гэнэ лээ.Тэр дуган сүм барих энэ тэр, тэр зүмбэр энэ тэр цутгах тэрүүнд Хятадуудаасаа зарим талаараа даваад байдаг байсан гэнэ лээ.Тэр хоёр бол хоёулаа л тэгээд баригдаад явсан, бүү мэд.Тэгээд л хэлмэгдээд өнгөрсөн.

Гантулга: Энэ хүрээн дээрээ бол тийм уран дархан улсуудыг сургадаг урлахуйн ухааны дацан байсан энэ тэр гэж дуулаагүй юу?

Ням: Үгүй.

Гантулга: Уулаасаа л тийм уран улсууд?

Ням: Уулаасаа л тийм удам дамжсан, тэр Дарханыхан гэж ярьдаг. Тэр Дарханыхан шилийг цоолоод, тэрнийгээ хадаасаар хатгаж тавлаад хагалалгүй хадаж чаддаг болохоороо л нэг алхыг бие биендээ дамжуулж явдаг.Одоо тэр алх нь ч хог дээр хаягдаад тэгээд, манай нэг хүүхдийнд хотод байна уу, үгүй юу.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Аан за.

Ням: Тийм үе дамжсан, Дарханыхан гэж одоо Сайхан-Овоо, Дэлгэрхангай энүүгээр Дарханыхан гэж учиргүй олон хүн бий.Тэднүүдийн л удам байх.

Гантулга: Одоо энэ том хутагт хувилгаанууд нэг айхтар, одоо малын энэ хижиг ч юм уу, эсвэл бороо хүр орохгүй нэг айхтар байгалийн янз бүрийн юм болоход ч гэдэг юмуу, чөтгөр буг шүглээд байхад дарсан ч юм уу нэг тийм сонин домгууд байдаг ш дээ?

Ням: За.

Гантулга: Тийм юм дуулсан юм байна уу , энэ хүрээ хийдээсээ хийдийн лам нартай холбоотой? Эсвэл ойролцоо энэ шүтлэг, тахилгатай уул нь тийм дошгин сахустай, тэгээд дошгирчихсон үед нь ингэсэн ч гэдэг юм уу тийм дуулсан юм байна уу?

Ням: За тийм дарсан барьсан гэж тийм дуулсан юм алга.Тэр Шанхайн Ширээт гэдэг лам наашаа энэ Хошуу хийд рүү явдаг юм байна аа.

Гантулга: Аа тэр нь Шанх гэдэг чинь?

Ням: Шанхай./Говь шанхыг хэлэв бололтой/

Гантулга: Аа бүр Шанх

Ням: Шанхай. Одоо Цогтцэций. Тэндээс тэр лам наашаа явахдаа архи уудаг лам байсан байгаа юм.Тэгээд олон лам нар дагуулчихсан, та нар цувтай явна шүү хө гээд л ингэдэг юм байна.За ламтан одоо Хошуу хийд дээр очиход ямар айлчлалтай очихов дээ.

Гантулга: Юутай очихов?

Ням: Айлчлалтай.Өнөө бусад лам нар нь тэгэхгүй юу, өө ганц л юм хэлье. Би бороотой очно оо. Тэгээд өнөө чинь Хошуу хийд рүү давхидаг юм байна.Тэгээд давхиж байгаад зуураа архи уугаад явдаг юм байна.Архи уугаад согтоод жаахан унтчихлаа гэнэ.Унтаж байхдаа амандаа ганцаараа яриад байх юм гэнэ, тэгээд бусад лам нар нь хараад суугаад байх юм гэнэ.Тэгж байснаа гэнэт, аа явна аа цуваа өмсчих бүгд.Уг нь нартай жигтэйхэн, бороо мороо орох янзгүй, гэхдээ яахав ламын үгнээс зөрөлтэй биш.Тэр үед чинь одоогийн дарапархуу юм уу даа тийм цувтай л байсан юм.Тэгээд цугаараа цуваа өмсчихөөд за одоо яваад байгаарай.мань хүмүүс л тэгээд яваад байж. Явсаар байгаад ирэхэд нь яг бороо асгаж байсан байгаа юм.Тэгээд ирээд тэр том лам нарт нь за би танайд бороо хүр авчирж ирлээ шүү гэж. Тэгээд ирээд өөрөө унтаад өгдөг хүн юм.Үгүй ээ ламтан, ингээд хашаа хороо нураад тогтохгүй байна. Бороогоо зогсоож хайрлаач гээд л .Өө тэгж байснаа, цувтайгаа унтаж байсан юм гэнэ. Цуваа тайлснаа гараад явсан.Тэгээд л бороо тогтож байсан гэсэн шүү. Тэр бол ухаандаа одоо тэр хүний л ид эрдэм.

Гантулга: Тийм, эрдэм чадал.

Ням: Тийм л юм байна даа.

Гантулга: Их сонин сайхан юм байна аа, наад түүх чинь. Өөр одоо танай энэ Хошуу хийд чинь ойр хавийнхаа уул усыг тахидаг байсан байх даа?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ням: Тахина аа. Тэгэхээр энэ Чандмань гэж баруунтаа байгаа.Тэрнийг тахина. За тэгээд тэр жижиг лам нар энэ Баян тахилгат гэдгийг тахиж байсан юм гэнэ лээ.

Гантулга: Тахилгатай? Тэр чинь?

Ням: Энэ Баян уул.Энэ Баянд чинь тахилга гээд нэг овоотой шомбойсон юм бий. Тэрнийг одоо тахилга гээд усны нэр л болчихоод байгаа юм аа.Тэгж байсан юм гэнэ лээ.

Гантулга: Жижиг лам нар гэдэг нь жоохон залуу банди нар гэсэн үг үү?

Ням: Аа тэгээд энэ Чандманийг тахидаг, хойд хоёр хийдийн лам нар.Хошуу хийдийн лам нар зүгээр, Чандмань чинь зүгээр өнгө нь мэдэгдэхээ больчихсон байдаг байсан юм.

Гантулга: Бүгдээрээ очдог байсан?

Ням: Бүгдээрээ оччихно.Очоод яах вэ гэхэлээр жаал жүүлхан овоотой, овоо болгон дээр нь очоод сан тавиад яваад байна.Тэгээд явсаар байгаад одоо тэр Хутагт ламын билүү, Ламын овоо л гэдэг юм.Чандманий хамгийн том овоо байдаг юм.

Гантулга: Тэр жаал овоо болгоноо тахиж уу?

Ням: Өө жижиг жижиг, одоо энэ барааны үүдэнд байгаа шиг нь л нэг бандийн овоо.

Гантулга: Тэгээд л бараг хүний нэг овоо шахуу юм уу?

Ням: Тийм.

Гантулга: Тэр олон овоо байдаг байх даа?

Ням: Өө тэр жижигхэн уул юм чинь олон овоо байлгүй яахав.

Гантулга: Хэдэн өдөр тахидаг байсан, нэг өдөр л тэгээд явчихдаг байсан уу?

Ням: Өө нэг өдөр л тахичихна.

Гантулга:Чандмань ,Тахилгат өөр тэгээд?

Ням: Хошуу хийдээс ч ондоо юм үгүй юм байх аа.

Гантулга: Энэ Тахилгат, Чандмань эд нар чинь Хошуу хийдээсээ яг зүг чигээр нь яривал, Хошуу хийдээсээ яг харж байгаад яривал зүг чигээрээ?

Ням: Чандмань энэ баруун хойно нь.Тахилгат нь зүүн хойно нь.

Гантулга: Аан. Холгүй биз дээ, тиймээ ойрхон?

Ням: Өө нэг арав арван км хавьцаа л.

Гантулга: Та түрүүн хэлж байсан ш дээ, тэр Өлзийт гээд , Мааньт гээд бас овоо байсан гээд? Бас тэрийг Хошуу хийдээс яаж байсан уу?

Ням: Тэрнийг ч нэг их тахиж байгаагүй юм.Хэдэн онд ч юм бэ дээ, нэлээн дээр үед юм байх аа даа. Нэг тахидаг наадам хийсэн юм гэнэ лээ.Тэгээд тэрнээс хойш наадам хийгээгүй.Одоо харин энэ жил чинь тэрийг тахиж байгаа гээд бас нэг бригадын...

Гантулга: Та тэр овоон дээр юу байсан гэлээ, маанийн үсэг байсан гээд та түрүүн хэлж байсан?

Ням: Тийм, маанийн зургаан үсэгтэй зургаан тууший байсан. Удаан байсан тууший даа.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Тэр нь тэгээд одоо бий юу?

Ням: Одоо байхгүй.

Гантулга: Тэр яасан?

Ням: Өө тэр тэгээд үрэн таран болоод , одоо хашаа машаанд орсон уу яасан тэгээд л алга болсон

Гантулга:Хэдий хэмжээтэй байсан бэ?

Ням: За энэний хэмжээтэй хэдэн юмнууд л даа, тэр түүний.Өндрөөсөө ямар ч байсан 50 см, уртаашаа нэг жар далан см байсан байх аа.Тийм хэмжэний зургаан түүний л байсан.

Гантулга: Онгийн гол молдоо Дүйнхорын, Дүлцэнгийн шороо гээд тийм юм хийдэг байсан уу? Гол мол, лусаа тахих?

Ням: Дүлцэнгийн хурал гэж Хошуу хийд жар хоног хурдаг байсан юм гэнэ лээ.Тэрнийг жар хоног хурахад тэрүүнд одоо газар газраас шороо мориор авчирдаг байжээ.Тэгэхээр одоо миний бодож байгаагаар, таааж байгаагаар Эрдэнэтээс авчирч байсан байгаа юм.Баруун урт яваад тэр Гурвантэсийн наад Алтны булаг гэдгээс авдаг байсан байгаа юм.

Гантулга: Одоо тэр ямар шороо авах уу, тэндээс?

Ням: Одоо тэр алттай малттай байдаг юм уу, тийм л шороо байдаг юм.

Гантулга: Өнгөтэй чулуу ч юм уу, тийм ээ?

Ням:За тийм, нунтагийн чулуу л байсан байгаа юм.Тэгэхээр алтад шиг, боронзод шиг тийм л ...

Гантулга: Будагтай чулуу гээд л ?

Ням: Аан?

Гантулга: Будагтай чулуу гээд л дүйнхорын хорол маналыг чинь янз бүрийн өнгөтэй юмаар хийгээд байдаг ш дээ?

Ням: Үгүй. Манай энэ зүүнд элст л гэдэг юм, одоо хавийнхан ч Зөөлөн овоо гэдэг болж билээ.Тэр элстийг аваачиж арвижуулж холидог байсан юм.Жар хоног хурал хийгээд , Онгийн гурван булагт хийдэг.

Гантулга: Гурван булаг гэдэг нь ямар ямар булаг, хаанаа?

Ням: Гурван булаг байгаа.Тэр Чандманий Хошуу хийдийн баруун хойно, голын баруун талд нэг булаг байсан.Одоо тэр урд байгаа, энэ мэднэ, тэр өтрийн тэнд замын бууц гэдгийн яг баруун шуудуунд гадаа нь нэг булаг байсан.Өмнө но төмөр гарт нэг байсан гэж байгаа.Тэгэхээр тэр замын бууцан дээр би байсан болохоор андахгүй юм.Тэр лүүгээ аваачаад л нэг уртгүй уурга хийчихээр , доошоо тулахгүй.

Гантулга: Өө за, хачин гүн булаг, гүнзгий?

Ням: Тийм. Тэр хойгуурх нүдэн булаг гэдэг нь ч бас тийм байсан юм гэнэ лээ.Тэр өтрийн тэнд бол бас мал аваачиж үхдэг тийм бас л хөлгүй ус гэж нэрлээд байдаг юм.Тэгээд одоо өтрийн чин тийшээ нүүчихсэн юм гэнэ.

Гантулга: Тэр Задгай байх нь ээ?

Ням: Булаг байхгүй.Энэ хойгуурх хоёр булаг байхгүй.Ноднин, уржнан намайг очиход тэр замын булаг бараг алга болсон, тээр доор нэг.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Тэр Дүйнхорын хурал тэдэн сарын зуны эхэн сарын шинийн тэдэнд ч гэдэг тийм хоног хугацаа байгаа байх даа, эхлэхдээ?

Ням: Мэдэхгүй.

Гантулга: Тэрийг бол мэдэхгүй юу, өөр одоо сайн зурхайч нар ч гэдэг юмуу, зурхай зурдаг хүмүүс байдаг байсан байх даа? Эм зурхай, эмнэлэг зурхайны талаар том нэртэй маарамба янз бүрийн тийм өвчин хижиг эдгээдэг тийм нэртэй дуулсан улсынхаа талар, энэ Хошуу хурлынхаа талаар?

Ням: За Говь түшээ гүний хошууны, хошууны зурхайч шүү.

Гантулга: За.

Ням: Доёд гэдэг зурхай байжээ.Доёд Ламын хийд дээрээ , уг нь хар хүн байсан юм гэнэ лээ. Сүүлдээ даа лам болсон юм гэнэ лээ.

Гантулга: Ламын хийд дээрээ ирээд үү?

Ням: Тийм.Тэгээд энэ Доёд гэдэг зурхайчийн зурхайг нь хуулбарласан юм. Ер нь хуулбарлаад үе дамжчихсан юм. Тэрнийг л энэ бичиж явдаг.

Гантулга: Барьж явдаг?

Ням: Тийм.

Гантулга: Тэгээд Ламын хийд дээрээ л байсан хүн үү, тэр Доёд нь Хошуу хийд дээрээ байсан үү?

Ням: Ламын хийд дээр.

Гантулга: Тэгэхээр эндээ тэрийгээ барьдаг?

Ням: Тэгэхээр энэ Говь түшээ гүний нийт цугаарангийн нь зурхай зурдаг байсан.

Гантулга: Зурхайг нь зурдаг, хэтийг нь зурдаг?

Ням: Би нэг номон дээрээс харсан. Говь түшээ гүний Доёд зурхайч гэдэг Халхын их зурхайч гэгдэж байсан юм аа гэж.

Гантулга: Тийм ээ, би дуулж байсан юм байна, Тэрбиш зурхайчийн зохиол дээр байсан юм байна?

Ням: Тэгэхээр тэрүүнийг яах үү гэхлээр ...Богдын шар зурхайч , хар зурхай гэж байжээ.Хоёр зурхайч хоорондоо тэрсэлджээ.Хоёр зурхай гаргасан чинь хоорондоо таардаггүй.

Гантулга: Минийх зөв л гэнэ?

Ням: Минийх зөв, минийх зөв. Тэгээд хоёулаа Доёд зурхайч дээр очиж гэнэ. Хоёулаа хоорондоо муудалцаж таарна шүү дээ.

Гантулга: Тэгнэ тэгнэ.

Ням: Богдын хүрээнээс мориор гараад наашаа ирсэн байна.Энд ирээд бид хоёр ингээд зөрөлдчихөөд байна.Тэгээд миний зурхай энэ гээд үзүүлж, тэгээд Доёд зурхайч үзэж байгаад зөв л байна гэж гэнэ.За минийх бурууддаг юм байна, гээд нөгөө дэх нь зурхайгаа гаргаад үзүүлж гэнэ. Зөв л байна. Өнөө чинь хоёулангийн нь зөв байна.Тэгэхээр чи тэр хошууны хүн үү, чи тэр хошууны хүн үү.Танайд нар бол төдийд мандана, танайд

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

төдийд мандана. Тэрүүгээр нь зөрж байгаа юм.Та хоёр юмаа сайн хэлэлцэж байж шийд.Тэгээд тэрнээс хойш хар зурхайч, шар зурхайч хоёр тэр Доёодод шавилан сууж.Тэгээд буцаж очоод зөрөхөө байсан юм гэнэ лээ.

Гантулга: Одоо тэр маарамба нарын талаар дуулсан юм байна уу, танд? Маарамба?

Ням: Мэдэхгүй.

Гантулга: Том том гавж нар ч юмуу, одоо энэ Чойрын лам нар ч юмуу ном барих, гүн ухааны гэвш нар одоо мордоно зордоно гээд л ярьдаг. Тийм ёслолын талаар дуулсан юм байна уу?

Ням: Алга аа.

Гантулга: Домын дамжаа эд нар барьдаг байсан гэсэн?

Ням: Тийм, дамжаа л бариад байдаг байсан. Энэ одоо Хошуу хийд дээр тэр ямар юм гээчийн саарал дором гэж гарч л байсан юм гэнэ лээ.Зүгээр гавжийн дамжаа бол түүс юм аа.Энэ шашин сэргээж байна гэхэд тэр Дундговь тэрүүнд хичнээн лам байсан гэлээ, хуучин тэр мяндагтай хүн хоёрхон гавж байсан юм.Нэг л тэр би түрүүн хэллээ, Цэвэгнамжил гэж байсан гэж. Нэг нь Эрдэнэ далайн хамба байсан Цэрэнчимэд гэдэг хүн байсан.Уг нь Сайхан –Овоогийн гарлын хүн юм гэнэ лээ.

Гантулга: Одоо та бидэнд энэ, та бага байсан үедээ бол зах зухаас нь бас мэднэ гэж ярьж байсан ш дээ.Түрүүн бас хэлж байсан, сүм хийд хаасан , хэлмэгдлийн үеийн талаар жаахан ярьж өгөхгүй юу, энэ хүрээ хийд хаагдад лам нар нь хаашаа баригдаад явсан юм, зарим буцаж ирсэн улсын яриа хөөрөө ч байдаг юм уу? Сүм хийдийнх нь байшин барилга, дуган нь бүтэн үлдсэн юм уу? Нураад тэр дор нь үгүй хийчихсэн юм уу, энэ талаар жаахан ярьж өгөхгүй юу?

Ням: За тэр юу юм гэнэ лээ, тэр Хошуу хийдийг яг тэр, хамгийн гол нь Майдрын дуганд л байсан байна даа. Тэгээд л бусад нь л байлгүй дээ.Тэрүүнийг байж байх үед за өнөө Маршал Чойбалсан гэдэг Өмнөговь явж байгаа юм гэнэ.Улс амьтан шуугиж байсан.Өмнөговь дээр очоод Хошуу хийдийг буулгахаа хүлээ, түр азна гэдэг юм байх.Тэгээд нөгөө хуучин үсгээр биччихсэн байдаг юм, тэрийг нь далимдуулаад түргэн буулга гэж байна гээд дайрчихсан юм гэнэ лээ.Тийм, тэгээд сүйтгээд хаячихсан юм гэнэ лээ гэж сүүлд дуулдаж байсан.

Гантулга: Ер нь бол тэр буулгах...?

Ням: Тэгэхдээ тэр үед бас зарим буцаж ирсэн лам нар нь ярьдаг байсан. Өмнөговь дээр одоо очоод яахав гэхлээр ламын хэрэгт орчихсон улсуудыг за нэг байцааж асуусан болоод, сүүлд нь хөшигний цаанаас хүн байцаагаад байдаг байсан.

Гантулга: Өөрөө үзэгддэггүй?

Ням: Тийм хөшигний цаанаас. Тэгсэн тэр сүүлд бол яахав, тэр эсэргүү хүн байжээ. Дорноговь аймгийн нэг мундаг лам хэлтсийн дарга болчихсон байна лээ гэж тийм нэг домог байдаг юм .Үнэн ч юмуу, худлаа ч юмуу мэдэхгүй.Тэгээд ерөөсөө эндээс том голч лам эд нарыг ер нь тонгойлгочихсон байх аа .За гэхдээ, зарим сүүлийн үед манай эндээс хар далай хүртэл амрах гээд яваад хүүхэд хар далайд очиж амардаг юм байна.Тэднуудын үйлчлэгч нэг монгол өвгөн байдаг юм байна.Яах аргагүй монгол.

Гантулга: Хар далайд байж байдаг уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ням: Тийм.Тэр Оросоор яриад байх юм гэнэ лээ, одоо.Харвал яг монгол ингээд байж байсан.Тэгээд нөгөө амарч байгаа жаал охин байсан юм байна л даа, тэрнийг л бараадаад байх юм.Тэгж байгаад нэг хоёр салаа зам таарчээ. За хүү минь, чи Жалчаа овогтой гэж байх нь тэр. Бадайн Жалчаа мөн үү, гээд монголоор тэгж байх юм.

Гантулга: Үгүй ер гэнэт?

Ням: Би монгол хүн байна аа. За даа хэнд ч битгий мэдэгдээрэй. Энэ захиаг Жалчинд аваачиж өгөөрэй гэж.Өнөө хүүхэд чинь Оросоор яриад байсан бор өвгөн чинь гэнэт Монголоор яриад байхаар цочдог юм байна.Тэгсэн чинь тэр хүүхэд нь эцэг нь Жалчин гэдэг хүн байгаа юм.Тэгсэн тэр Жалчингийн нэг танил Хошуу хийдэд байсан хүн, тэр цөлөгдөөд Хар далайд оччихсон юм байгаа юм.Тэгээд тэндээс захиа ирж миний ах дүү төрөл саданд чи нууцаар намайг эсэн мэнд гэж мэдэгдээрэй гэж тэр Жалчинд тийм захиа ирсэн байгаа юм. Өөрийн нь эсэн мэнд гэж. Тэгээд тэр Жалчин өвгөн намайг за чи Нямаа тэрүүнд хэл хүргэ, энүүнд хэл хүргэ гэж хэл хүргүүлж л байсан юм.Тэгэхээр тэр хүн Хар далайд цөлөгдсөн юм байна аа гэж.

Гантулга: Бас хагас нь , тийм ээ?

Ням: Тийм.

Гантулга: Тэгэхээр тэр Чойбалсан гуай Өмнөговь руу явж байна гэдэг чинь Чойбалсан гуай өөрөө гардаж, өөрөө ерөнхийд нь удирдаж байсан болох гээд байна аа даа?

Ням: Хай даа, одоо түр азна гэснийг нь л түргэн нураа гэсэн гээд л...

Гантулга: Тэр үед чинь одоо тэр , хошуу нутгийнхаа засаг, сумын засаг дарга байсан хүн нь энэ нутгийн л хүн байгаа ш дээ.Тэр хүмүүс нь ямар хүмүүс байсан юм, тэр чинь дээрээсээ заавар зөвлөгөө аваад л хийсэн байгаа ш дээ, тэр улсуудынх нь нэрийг мэдэх болов уу?

Ням: Тэр үеийн Дэлгэр хангайн 1-р баг чинь энэ голд байсан юм ш дээ, нутаглаж байсан юм.Тэгэхлээр чинь оолон дарга нар байсан.Цоохор Пүрэв ч гэж байлаа, Дашчондог ч гэж байлаа.Мятавдорж гэж ч байлаа.

Гантулга: Энэ тэгээд яг аль талдаа хамаарах вэ?

Ням: Арай сүүлхэн юм уу даа. Манай аав ч байсан.Одоо цугаараан байхгүй. Хэдийд үхээд дууссан.

Гантулга: Энэ тэгээд аль , Дэлгэрхангайдаа харъяалагдаж байсан юм уу, энэ Мандал-Овоодоо харъяалагдаж байсан юм болов уу, энэ улсууд чинь?

Ням: Дэлгэрхангайд харъяалагдаж байсан.

Гантулга: Тэгэхдээ тэр Онгийн гол энэ хавиа хариуцаж байсан уу, тийм ээ?

Ням: Тэгэлгүй яахав. Одоо энэ наахна яваад Хомсын уул гэж байна. Тэрнээс нааш чинь тэр чигтээ Дэлгэрхангайн нутаг байсан юм.Тэгэхээр ер нь Хошуу хийд гэдэг чинь Дэлгэрхангайн нутаг шүү дээ.

Гантулга: Энэ тэгээд хуучнаараа бол Мандал-Овоогийнх гээд улсууд яриад байх юм байна ш дээ?

Ням: Өө яахав, газар зохион байгуулж байгаа нь энэ гээд, тэр Хошуу хийдээ олдог юм уу яадаг юм.Энд нэг жоохон газар Дэлгэрхангайнх болсон юм.Тэр хар Хомс гэдэг бол байхгүй. Ер нь Мандал-Овоо эзэлчихсэн дээ.

Гантулга: Тэгээд одоо энэ сүм хийдийг нураах, дотор нь эсвэл төвлөрөөд засгийн ажил хийх ч байдаг юм уу тийм юмыг нь гардаж хийсэн улсуудын талаар, одоо тийм юмыг нь тэгж конторлоод тийм юм хийж байсан гэж

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

дуулсан юм байх уу? Одоо энэ нурж тараагүй хийдийнх нь туурин дээр түрүүн нэг хүнээс сонссон чинь энэ Өмнөговийн мал тууврын бааз байсан гэж?

Ням: Тийм ээ тийм. Мал хашаа бааз байсан юм.

Гантулга: Өмнө нь таныг байх үед бол, ингээд лам нарыг нь хөөгөөд сүм хийдийг нь цөлмөөд заримыг нь нураагаад, зарим нураагүй байсныг ашиглаж байсан юм байна уу?

Ням: Өмнөговийн мал тууврын бааз л байсан юм.

Гантулга: Тэрнээс өмнө?

Ням: Тэрнэс өмнө ч Дэлгэрхангайн сумын нэг дөрвөн ханатай газар байсан юм, тэр Жавхлантэс чинь.

Гантулга: Сумын контор?

Ням: Багийн контор.

Гантулга: Аль багийн контор байсан юм?

Ням: Дэлгэрхангайн 1-р багийн контор.

Гантулга: За тэрнээс өмнө?

Ням: За тэрнээс өмнө ч нөгөө жас масаараа байж байгаад...Цогчин жасын манзны байшин гэдэг ганцаараа үдлсэн байсан юм.Одоо тэр Намсрайн дуган гэдгийн чинь уул дуган үлдсэн байсан юм.За тэгээд л тэр сүүлд лонгийн бааз нь байж байгаад тэгээд тэр цогчин жасын манзны байшинг нь яаж ийчхэв дээ, тэгээд л үрэгдсэн байх. За тэр Намсрайн дуган нь одоо энэ Ламын хийдээсээ дуганы орой дээр байна.

Гантулга: Та тэр цогчин дуганых нь гол нандин шүтээн нь Улаан жамсран гээд түрүүн хэллээ ш дэ, тийм ээ?

Ням: Тийм.

Гантулга: Одоо бусад дуганых нь нандин шүтээн тийм Халхад ховор ч гэдэг юм уу, бурхан шүтээн, сүм, ном суварга одоо тэр Гэрэлт суварга ч гэдэг юм уу тийм онцгой хавь ойрынх нь хүмүүс шагшдаг тийм шүтээнүүдийнх нь талаар дуулсан юм?

Ням: Мэдэхгүй.

Гантулга: Одоо энэ сүм хийдийг нь дахин сэргээсэн барьсан юм байхгүй юм байна ш дээ, тийм ээ?

Ням: Байхгүй. Тэр жил энэ Дэлгэрхангайхан нэг яригдаж ирээд, Дэлгэрхангайдаа нэг гэр барьчихаад , гэр бариулчихсан тэгээд тэндэ хэдэн хүүхдүүд төвхнөчихсөн. Одоо нэг жоохон залуу, согтуу ламд л тэр гэрийн түлхүүр байдаг юм уу, үгүй юмуу.

Гантулга: Энэ уг нь болвол Дэлгэрхангайхан энэ Онгийн юугаа сэргээе гэж ярьдаг юм уу?

Ням: Нэг ярьцагасан юм.

Гантулга: Тэр одоо яг Онгийн хуралд хүрж байсан хөгшчүүл бол ерээд оны үед , одоо Дэлгэрхангайд хүрж байсан хөгшчүүл бол байдаг байсан юм байна ш дээ, тийм ээ?

Ням: Байсан.

Гантулга: Гэртээ юмаа хадгалчихсан тийм ээ?

Ням: Тийм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Тэгээд өөрсдөө бас арай нэг их удаагүй, анагхан байсан юм байна ш дээ, тийм ээ?

Ням: Тийм.

Гантулга: Тэд нар нь бол яг өөрсдийн санаж бодож байсан юмаа энэ Дэлгэрхангай сумандаа л төвлөрүүлсэн юм байна ш дээ, тийм ээ?

Ням: Тийм. Одоо бид нар тэгээд холдчихоод хэн нь тэндээ байх вэ, хэн нь сүүх вэ. Би нэг дагуул хүүхэдгүй бол сууж чадахгүй, ийм юм болоод. Ерөөсөө сумынхаа төв дээр...

Гантулга: Тэр хөгшчүүлээс одоо нэрлэвэл?

Ням: Одоо байхгүй ээ, үхчихсэн.

Гантулга: Үгүй ээ яахав, тийм тийм хүмүүс байсан гээд, Онгийн хурлын тийм тийм хуваргууд байсан гээд? Нэрлэвэл?

Ням: Одоо тэр Цэвэгнамжил гэж байна, тэр Олдохын хийдэд ч суудаг, энд ч суудаг Даансран гэж байсан байна.Бархас ч гэж байлаа.

Гантулга: Зэрэг мяндаг нь?

Ням: За тэрүүн дотроос болвол тэр Цэвэгнамжил гэдэг нь л гавж, бусдангууд нь бол дандаа гэлэнгүүд.

Гантулга: Аа мөн зүгээр гэлэнгүүд?

Ням: Тийм.Энэ Өмнөговийн хэмжээний бүх хийдүүдийг, хөрөнгийг нь хурааж, ламыг нь барьж ингэж сүйд хийж байсныг нь мэднэ шүү дээ.Хамгийн гол нь Сайхан –Овоод сахал Юндэн гэдэг хүн байсан юм.

Гантулга: Аймаг даяараа л ер нь энэ бүгдийг гардаж хийсэн хүн?

Ням: Аль хошууны аль хийд рүү явах хэрэгтэй байна.

Гантулга: Сахал...?

Ням: Сахал Юндэн.Ямын Юндэн гэдэг юм.Юунд Мандал-Овоод бол Сэмээлий гэж байсан юм.

Гантулга: Сэмээлий?

Ням: Тийм.

Гантулга: Лам байсан улсууд уу, эд нар чинь зүгээр хар байсан уу?

Ням: За даа банди нар ухаантай юм. Нэг л зодолдохоос ондоо юм мэддэггүй хогийн банди нар байж байгаад л ...Тэгээд сүүлд нь л...

Гантулга: Бүр хувьсчихсан?

Ням: Тийм.

Гантулга: Тэгээд л ерөөсөө тэр сүм хийдийн л юм байвал тэрийг нь нүд нь үзэж чаддаггүй?

Ням: Тэр сахат Гэндэнгийнх гэдэг айл бол дууслаа. Сахал Гэндэнгийнх гэдэг айлд бол яах вэ гэхлээр зэрэг, за даа юу гэх юм бэ дээ...За ямар ч байсан энэ нэг модон сандал шиг уутаар дүүрэн хөөрөг байсан юм. Тэр лам нарын л хөөргүүд, нэг ялбийсан ялбийсан муу сайн тийм мөнгөтэй юм байна.

Гантулга: Мөнгөтэй?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ням: Эрмэл. Ганц нэг мөнгөн аяга байсан л байх.Тэгээд өөрөө сүүлд нь баяжаад үлдэцгээсэн.Тэр байхгүй ээ байхгүй. Үхээд нэлээн хэдэн жил болсон.

Гантулга: Энэ одоо Хошуу хийдийн туурийг улсууд очиж ухаж барьж байна гэж нэг дуулсан юм.Тэр талаар та дуулсан юм байна уу?

Ням: Улсууд ухлаа л гэдэг юм.

Гантулга: Тийм юм оллоо гээд, одоо бурхан шүтээн энэ тэр гээд?

Ням: Аа нэг жижиг жижиг бурхнууд олсон л сурагтай байсан. Нэг тохой бурхан оллоо л гэж энэ тэр ярьдаг юм.

Гантулга: Энэ хийд дээрээ ном хэвлэж байсан , тийм юм дуулаагүй юу та?

Ням: Аан?

Гантулга: Хуучнаар бар гэдэг байсан ш дээ? Том хийдүүд, тийм юм дуулсан юм байна уу?

Ням: Бартай байлгүй яахав.Энэ чинь барладаг тусгай улсууд байна, тэгээд барын хэв сийлдэг хүмүүс байна.

Гантулга: Та ер нь тэрийг сайн мэдэж байна уу?

Ням: Мэдэлгүй яахав.

Гантулга: Одоо тэр барыг нь та харж байсан уу?

Ням: Үгүй, хэн мэдэхэв. Нэг тангад үсэгтэй л ...

Гантулга: Модон...?

Ням: Модон бар л байдаг байсан.Оонондэмбэрэл гэдэг хүн сийлдэг байсан.

Гантулга: Оонондэмбэрэл ээ?

Ням: Тийм. Бас аль хэдийд л үхсэн.

Гантулга: Тэр бас уран хүн байсан уу?

Ням: Байхгүй ээ мэдэхгүй.Сүүлийн үед Цэрэннадмид гэдэг өвгөн байж байгаад л үхсэн юм.Тэр бурхантыг чинь барлаад л сийлээд л ...

Гантулга: Хошуу ноён нь хэн гэж хүн байсан бэ, хошуу ноёныхоо талаар яриач?

Ням: Хошуу ноёных нь хамгийн сүүлийн нь Лхагважав гэж хүн байсан юм гэнэ лээ.

Гантулга: Одоо хуучны аймаг, хошуугаараа яривал Түшээт хан аймгийн...?

Ням: Тийм.

Гантулга: Түшээт хан аймгийн ямар хошуу байх вэ?

Ням: Дэлгэрхангай уулын хошуу.

Гантулга: Аа тийм. Тэрнээсээ өмнө?

Ням: Мэдэхгүй.

Гантулга: Говь Түшээ гүний гээд хошуу гээд та түрүүн хэлж байсан ш дээ?

Ням: Тийм, Говь...За мэдэхгүй ээ.Түшээт хан гэдэг чинь Хэнтий аймаг руугаа орчихно биз...

Гантулга: Үгүй ээ, Түшээт хан аймаг гээд аймгаараа юу болно л доо.

Ням: Дэлгэрхангай уулын хошуу байсан юм. Тийм ээ тийм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: За сайхан ярилцлага өгч бидний ажилд тус нэмэр болсон таньд гялайлаа.

Ням: За зүгээр.

Гантулга: За маш их сайхан юм ярьж өгсөнд танд баярлалаа.